

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-39
1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	12-34
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	34-38
3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	38-39

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 21-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Х.Ганхуяг, Б.Заяабал;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, П.Мөнхтулга.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг хуралдаагүй байгаа тул ажлын хэсгийн санал, дүгнэлт сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	5
Бүгд:	14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 3 дугаар байгаа ажлын хэсгийн санал, дүгнэлт сонсох асуудлыг хойшлуулав./09:27/

**Нэг.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын
хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Анар, Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Өнөржаргал, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Да.Цогтбаатар, Р.Батболд, Ж.Батжаргал, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШБС-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “46,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “28,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 13

Бүгд: 15

13.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний өртгийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШБС-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт бүрдэх хатуу хучилттай авто замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “137,500.0” гэж, Тухайн жилийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.11 дэх заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ -1.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Орхон аймаг орон нутгийн бонд гаргаж, томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж-д “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүнд “0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийг “0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Үнэт цаас” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.2.27” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Авто замын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “20 хувь” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жил шаардлагын санхүүжилтийн хэмжилттэй “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал, “Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” 1.1.1.12 дахь дэд заалт гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үзүүлэлт “ЗГҮАХ-3.3.3.42” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулах шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “50,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 1.1.1.12 дахь дэд заалт гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн бүсүүдийн тэмцэлтэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг хөтөлбөр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн хоршоодыг дэмжинэ.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.3.5.1, 1.3.1.4, 3.3.2.5, 3.3.2.22” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотод байгуулагдах бүсийн тээвэр логистикийн төвийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, батлуулах” гэж, Шалгуур үзүүлэлтийг “ТЭЗҮ” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,000.0” гэж, Тухайн жилд шаардах санхүүжилтийн хэмжээ “2,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар ТӨҮГ” гэж, 1.1.1.13 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат хариулж, тайлбар хийв.

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 2.3 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Олон улсад өрсөлдөхүйц, чанартай, тэгш, хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг бууруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.1.19, ЗГҮАХ-2.2.1.7”, Төсөл арга хэмжээ “Олон жил гацсан ерөнхий боловсролын сургуулийн барилга барьж дуусах” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орох сургууль” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “40,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “40,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж, 2.3.1.9 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 11

Бүгд: 15

26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Өрсөлдөх чадвартай, тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Дээд боловсролын үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.5” гэж, Төсөл арга хэмжээ “Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, Эрдэнэт хотод хотхон байгуулан шилжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж, 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 9

Бүгд: 15

40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.10.1.2 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Иргэдэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үзүүлэлт “АХ-2.2.4, 2.2.11, 2.2.27, ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл арга хэмжээ “Баруун бүсэд Зоонозын өвчин судлалын төвийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн 4,18 тэрбум” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,09 тэрбум” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч Эрүүл мэндийн яам” гэсэн 1.10.1.2 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2” гэж, Төсөл арга хэмжээ “Улаангом-Баруун туруун чиглэлийн 180км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “360 тэрбум” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36 тэрбум” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогын шалтгаалж Санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гараад байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.7 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр” гэж, “2024 онд” гэснийг “2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр” гэж, 3.1 дэх хэсгийн “2 дугаар сард” гэснийг “2 дугаар сарын 18-ны өдөр” гэж, 3.3 дахь хэсгийн “6 дугаар сард” гэснийг “6 сарын 16-ны өдөр” гэж, 3.5 дахь хэсгийн “9 дүгээр сард” гэснийг “9 дүгээр сарын 02-ны өдөр” гэж, 3.6 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.7 дахь хэсгийн “5 дугаар сард” гэснийг “5 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 2.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 04-ний өдөр” гэж, 3.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 04-ний өдөр” гэж, 3.11 дэх хэсгийн “2031 онд” гэснийг “2031 оны 10 дугаар сарын 28-нд” гэж, 3.12 дахь хэсгийн “8 дугаар сард” гэснийг “8 дугаар сарын 29-ний өдөр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 8.4 дахь хэсгийн “эхлүүлэх” гэснийг “тогтмол явуулах” гэж, “тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.” гэснийг “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6

Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын Стратеги 4-ийн “Улсын төсөв ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед” гэснийг “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй үед” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “түүхэн” гэсний өмнө “Засгийн газрын өмнө гаргаж байсан бондуудаас” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан” гэсний өмнө “баталгаа” гэж, 6.1 дэх хэсгийн “харьцааны төсөөллийг” гэсний өмнө “ДНБ-д харьцуулсан” гэж, 6.2 дахь хэсгийн “хэмжээг 2026 онд” гэснийг “ДНБ-нд эзлэх” гэж, Дүгнэлт хэсгийн “60,5 хувьтай” гэсний өмнө “2022 онд” гэж, “41,8 хувь” гэсний өмнө “2024 онд” гэж, “буурсан,” гэсний дараа “эдгээр онуудад” гэж тус тус нэмэх;

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх хэсгийн “оршино” гэснийг “чиглэнэ” гэж, “Сангийн яам нь стратегийн баримт бичгийг” гэснийг “Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг/цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/-ийг боловсруулж” гэж, 2.1 дэх хэсгийн “Цар тахлын” гэснийг “Ковид-19 цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын” гэж “2021 оноос 2024 оны хооронд нийт” гэснийг “2024 оны жилийн эцсийн байдлаар 2021 оны түвшнээс” гэж, “эзлэх хэмжээгээрээ” гэснийг “харьцуулсан харьцаа” гэж, 2.2 дахь хэсгийн “нэгжүүд” гэснийг “нэгж байгууллагууд гэж 3.2 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэснийг “нэмэгдүүлэх” гэж, 3.5 дахь хэсгийн “зээлийн эх үүсвэрийг” гэснийг “зээлийг” гэж, 3.9 дэх хэсгийн “буцаан төлж” гэснийг “бүрэн төлж” Хүснэгт 6-ын “өрийн зардал” гэснийг “өрийн багцын зардал” гэж, 5.4 дэх хэсгийн “буурах төсөөлөл” гэснийг “бууралт” гэж, Стратегийн 4-ын “бүх хэсгийн хүрээнд” гэснийг “нийт хэмжээнд” гэж, 5.8 дахь хэсгийн “үнэт цаасны гаргалтыг” гэснийг “үнэт цаасны арилжааг” гэж, 6.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн харьцаа” гэснийг “уг харьцаа” гэж, “өрийн харьцааг” гэснийг “уг харьцаа” гэж, 6.2 дахь хэсгийн “хүрээний мэдэгдэлд” гэснийг “төсөөлөлд” гэж “туссан дүнтэй” гэснийг “туссан хязгаарт” гэж тус тус өөрчлөх;

3.Тогтоолын төслийн 2.2 дахь хэсгийн “Голомт банкнаас” гэсний дараах “олон улсын зах зээлд” гэснийг, мөн хэсгийн “төрийн байгууллагуудын хувьд” гэснийг “болон гаргасан”, мөн “тус хугацаанд” гэснийг, 2.4 дэх хэсгийн “тогтмол” гэснийг 3.1 дэх хэсгийн “хуульчлагдаж” гэснийг, 5.8 дахь хэсгийн “түлхүү” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 09 цаг 24 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 ирсэн, 52 хувьтай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 2025 оны 5 сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /хоёр дахь хэлэлцүүлэг/

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг байгаа.

3.Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлт сонсох

4.“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу. Булгантуяа гишүүн. Булгантуяа гишүүний микрофон.

Х.Булгантуяа: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Манай ажлын хэсгийн хувьд ажлын хэсэг хуралдаж санал, дүгнэлтээ нэгтгэх гээд ажлын хэсгийн ирц бүрдэж чадаагүй. Тийм учраас өнөөдөр хэлэлцэх асуудлаас хойшлуулж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Тэр Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар явуулсан ажлын хэсгийн хуралдаан хийгдээгүй байгаа юм байна лээ. Тийм учраас энэ асуудлыг хойшлуулъя. Өөр санал байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё. Хойшлуулах санал хураалт явуулах юм уу. Тэгвэл 3 дахь асуудал. Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-9 дэмжиж, 64,3 хувиар уг асуудал хойшлогдлоо.

Хэлэлцэх асуудалдаа оръё гишүүд ээ. Эхний асуудал.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Л.Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд. Ажлын хэсгээ оруулаарай. Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Ж.Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Л.Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Бундхорол Үндэсний Аудитын газрын Тамгын дарга бөгөөд тэргүүлэх аудитор, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, З.Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Г.Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Т.Хонгор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна. Сайдыг дуудаарай.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Нэрээ өгье. Батжаргал гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн ороод ирсэн байна. Ж.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Энэ чинь ирцээрээ түрүүлчхэв үү. Би бас чуулган дээр асуусан. Энэ 2026 оны орлогыг ер нь яаж төсөвлөж байгаа вэ. Энэ жилийн гол алдаа бол бид нар орлогоо хэт их төлөвлөсөн шүү дээ. Тэгээд яах вэ? Гишүүд нөгөө нэг алдагдалгүй төсөв гэдэг рүүгээ л явчихсан болохоос биш орлогыг нь их анхаараагүй. Одоо энэ төлөвлөгөө дээр чинь тэгээд ажлын хэсэг гараагүй юм уу.

Ц.Даваасүрэн: Манай дээр бол нөгөө Эдийн засгийн хөгжлийн яаман дээр биш ээ, Эдийн засгийн байнгын хороон дээр явж байгаа.

Ж.Ганбаатар: Тэгээд орлогоо маш сайн төлөвлөх хэрэгтэй байна. Орлогоо ерөнхийдөө яаж бид нар ер нь 2026 онд ямар орлого олох гээд байгаа юм бэ. Тэгээд манай дэг их сонин л доо. Асуучхаад өөрөө хариулах хэрэгтэй болчихдог юм. Тэгээд энэ алт чинь өөрөө та нар алт гээд л яриад байх шиг байгаа юм. Алт үнэхээр шороон орд бол үнэхээр Монголд ер нь бараг багассан. Одоо нөгөө тусгай хамгаалалттай газар юм уу, тэр гол ус руугаа л орох гэж байгаа юм шиг

байна лээ. Тэр гол усыг чинь бараг 2014 онд билүү, 2015 онд өөрчлөлт оруулаад бараг авчихсан юм шиг байна лээ дээ. Тэр тусгай хамгаалалттай газар луугаа орох гэж байгаа би бол ингэж байгаль, юм юм руугаа дайрч болохгүй л гэж бодож байгаа.

Зэс бол Монгол Улсын ялангуяа Оюутолгойн зэс бол Монгол Улсад бол бэлэн мөнгө биш. Тодорхой хэмжээний татварын орлого л орох байх. Татварын орлого нь тэгээд АМНАТ нь хязгаарлагдмал. 5 хувиас ихсэхгүй. Эрдэнэт шиг биш. Тэгээд яаж орлогоо төлөвлөж байгаа юм бэ. Энэ 2026 оныхоо орлогыг зөв төлөвлөөрэй. Илүү орлого олоод байвал уг нь их сайн шүү дээ. Тэгээд чадахгүй байж баахан том том юм төлөвлөөд, тэгээд тэр нь улсаа дампууруулдаг. Тэгээд хэн хариулах юм бол.

Нүүрс хэт их төлөвлөсөн. Би нүүрсийг зүгээр 70 дээр орхичихоо гээд зөндөө хэлсэн дээ. 2024 оны намар 2025 оны төлөвлөгөө хэлэлцэж байхад. Хэрвээ тийм байсан бол өдийд энэ доллар ч бараг өсөхгүй байх магадлалтай шүү дээ. Тэгэхээр 2026 оны төлөвлөгөө улсыг хөгжүүлэх төлөвлөгөөгөө бид нар ер нь энэ их том төслүүд багасгаж чадсан уу, багасгаагүй юу. Эсвэл Их Хурал дээр орж ирээд нэмэгдчихсэн юм уу. Тэгээд хариулт сонсчихоод тэгээд би эргээд тодруулъя.

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэн байна. 4 номер хэн билээ. Албан тушаалаа хэлээд хариулъя. Хөгжлийн сайдыг дуудна шүү.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2026 оны хувьд бид нар яг зэрэгцүүлээд өргөн барьсан төсвийн хүрээний мэдэгдлийнхээ тоог улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөндөө бас харгалзаж явж байгаа. Орлогын тооцоолол, зарлагын тооцоолол, зарлагын хязгаарууд дээрээ.

Ц.Даваасүрэн: Да.Цогтбаатар гишүүнийг асуултад нэмчих.

И.Батхүү: 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг яг адилхан дүнгээр авсан байгаа. 33,4 их наяд төгрөгөөр. Энэ сүүлийн үед үүсээд байгаа гадаад худалдааны тарифын нөхцөл байдал олон улсын эдийн засгийн чиг хандлагыг бид нар 2 жил дараалан ер нь сөрөг үр дагавар үзүүлэхээр байгаа гэж харж байгаа. Ялангуяа манай гол экспортлогч зах зээл БНХАУ-ын эдийн засагт бол сөрөг нөлөө үзүүлэх олон улсын судалгааны байгууллагуудын тооцоолол гарч байгаа. Бид нарын хувьд бас өнгөрсөн жил хийж байсан 6,5 хувь гэсэн өсөлтөө энэ жилийн тооцоолол дээрээ 6 хувь болгож бууруулсан байгаа. Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг гаргаад энэ жилийн хэмжээнд экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр оны эхнээс анхаарч ажиллаж байгаа. Тэгээд төлөвлөгөөний хувьд бол 2026 онд нүүрсний экспортыг 93 сая тонн, зэсийн баяжмалыг 2 сая тонн, алтыг 20 тонн, төмрийн хүдрийг 9,4 сая тонн гэсэн тооцоололтой байгаа. Үнийн хувьд бол нүүрсийг 80 ам.доллараар тооцсон. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бол 85 ам.доллар гэсэн тооцоолол ирүүлсэн байгаа. Тэгэхдээ бид нар илүү болгоомжтой байдлаар тооцсон байгаа. Зэсийн баяжмалыг 2659 доллар, алтыг 2600 доллар, төмрийн хүдрийг 69 доллар гэсэн тооцоололтой байгаа.

Орлого тооцоолсон гол үзүүлэлт бол биет хэмжээ, үнийн хувьд ийм байгаа. Тэгээд бид нар бол эдийн засгийн өсөлт бусад тооцооллоо бас өмнө нь тооцоолж байснаасаа бууруулж тооцсон байгаа.

Ц.Даваасүрэн: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Алт бол хүрэхгүй дээ. Та нар сайн мэдэж байгаа шүү дээ наадах чинь. Тэгээд бүх байгаль руугаа бүгд рүү нь тэр тусгай хамгаалалт руугаа дайраад ч хүрэхгүй 20 тонн. Би бас энэ салбарт чинь ажиллаж байсан хүн шүү дээ.

Дээрээс нь наад нүүрс чинь хүрэхгүй. Тэгээд буруу төлөвлөнө гэдэг чинь нэг тийм мөнгөгүй байж мөнгөтэй юм шиг баахан юм худалдаад авчихдаг хүнтэй адилхан шүү дээ. Тэгээд тэгээд буруутав. Эсвэл зүгээр төсвөө алдагдалтай гаргаад, тэгээд л явах ёстой шүү дээ. Орлого буруу төлөвлөнө гэдэг чинь бүх юмыг будилуулж байгаа шүү дээ. Төсвөө алдагдалтай гаргаад л, тэрийгээ тэгээд эсвэл нэг юмаар хаах. Тэр чинь зөв зам шүү дээ. Ер нь дэлхийн улс орнууд тэгж л явдаг шүү дээ. Тэгээд л дараа жил ахиад л бүр нэг .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ерөнхийдөө санал хэллээ. Тэгэхдээ Сангийн яамныхан ч гэсэн ер нь бас ирэх жилийн төсөв төлөхдөө анхаарахгүй бол нүүрснээс дутах юм чинь бол 2, 3 тэрбумаар яригдана шүү. Доллароор. Тэгээд 1 жилийн дотор экспортын орлогыг 2, 3 тэрбумаар нөхчихдөг тийм мундаг тооцоо хийж бас болохгүй шүү дээ. Хэцүү. 1 тэрбум доллар олно гэдэг бол тийм амар юм биш. Тийм учраас энэ бүгдийгээ бас анхаараад, ер нь төсөв заавал алдагдалтай байна гэсэн юм хаана байгаа юм бэ? Дэлхийд 10-аад улс орон л алдагдалгүй төсөв баталж байна шүү дээ. Тэгэхээр энийгээ бас жоохон анхаарах шаардлагатай шүү. Да.Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Бид нар чинь бүр босоо Монгол уйгуржин бичгээрээ бичээд л янзын Монгол хэлэндээ хайртай хүмүүс болоод байсан. Одоо энэ орж ирж байгаа төлөвлөгөө дээр би өмнө нь хэлье гэж байгаад больё гээд больчихсон. Одоо хэлэхгүй бол болохгүй байна. Проактив хандлагаар эрчимжүүлнэ гэж байгаа юм. Энд тохирох Монгол үг олдоогүй юм уу 1 дүгээрт.

Тэгээд дараагийнх нь асуудал бол энэ төсвийн урсгал зардлыг бууруулна. ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар тооцоолно гэж байгаа. Жишээлэхэд 2026 онд ширээ сандал авахгүй. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээг хийлгэхгүй ч юм уу ийм тодорхой тооцооллууд нь та хэд дээр байгаа гэж найдаж байна. Энэ дээр байгаа бол тодорхой тоонуудаа хэлж өгөөч ээ гэж.

Тэгээд тэр хөгжлийн төлөвлөгөөний 3.3 дээр хөрөнгийн зах зээл болон банк санхүүгийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна гээд. Манай энэ хөгжлийн төлөвлөгөө өөрөө заримыг нь харахаар бүр төлөвлөгөө гэж хэлээд ийм юм хэлэлцээд сууж байгаадаа бүр ичмээр юм шиг санагдаад байгаа юм. Тэгээд юу нь ичмээр гэхээр цахим банк, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлнэ гэж юу гэж байгаа юм. Бараг бүх банк, хамгийн муу явж байгаа Төрийн банк хүртэл цахим банктай болчихсон шүү дээ. Тэгээд ийм юмыг бид нар төлөвлөгөө гээд Улсын Их Хурлаар хэлэлцээд сууж байхдаа ичдэггүй юм уу. Тэгээд энэ хөрөнгийн захыг хөгжүүлж, үйлдвэрийн салбарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ эх үүсвэрүүдийг бүрдүүлнэ гэж байна. Яаж. Энэ дээр яг тодорхой хариулаад өгөөрэй.

3.3.2 дээр банк, санхүү, даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчилж, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, гадаадын банкны салбар нэгж байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж. Одоо энэ банк санхүүгийн салбарт байгаа хууль, эрх зүйн орчин бол хангалттай бас тодорхой хэмжээнд гайгүй хуулиуд байгаа шүү дээ. Одоо юуг нь сайжруулах гэж байгаа юм. Бид нар энэ төртэй өрсөлдөөд явж байгаа Төрийн банкаа хувьчилж чадахгүй байж дахиад хууль, эрх зүйгээ муу байна гэж дайрч болохгүй байх. Ядахдаа Төрийн банкаа хувьчлаад, хэдэн цаастай болоод энэ өрсөлдөөнийг шударга болгоё гэдэг чиглэлд ажиллаж болохгүй юу. Гаднын банк санхүүгийн салбар дээрээс жишээлэхэд аль орны ямар банк Монголд орж ирье гэдэг саналаа илэрхийлсэн, уулзалт нь ямар түвшинд явж байгаа, 2026 онд яг аль нь нээгдэх юм бэ гэдгийг бас тодорхой хариулж өгөөч.

Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ. Ажлын байрыг нэмэгдүүлнэ гэнэ. Тэгэнгүүт жишээлэхэд Баянхонгор аймагт бол Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд зээлийн хүсэлтээ өгөхөөр нэрийг нь өөрчлөөд, нөгөө санааг нь ЖДҮ-ийнх нь хулгай хийгээд, цааш нь явуулчхаж байна гэж байгаа байхгүй юу. Бид нар энд төлөвлөгөө гээд гоё юм хэлэлцээд байдаг. Бодит байдал дээрээ ажил чинь ерөөсөө урагшилж өгөхгүй байгаа дээр ямар хариулт хэлэх вэ. Байр суурийг нь сонсоодохье.

Ц.Даваасүрэн: Хэн хариулах вэ. 2 номерын микрофон. Албан тушаал, нэрээ хэлээрэй.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар Эрдэнэбат. Энэ Проактив гээд гадаад үг орсонтой холбоотой тайлбар хэлье. Энд нэг яалт ч үгүй Монгол хэл дээр орчуулахад төвөгтэй хэдэн хэллэгүүд манай төлөвлөгөөнд байгаа. Ялангуяа эдийн засагтай холбоотой. Макро ч байдаг юм уу гэх мэт. Тэгээд энэ проактив гэдгийнх нь агуулга нь болохоороо одоо яг Монгол төрийн үйлчилгээ нэлээд хэсэг дээрээ пассив буюу хүлээлтийн байдалтай зарим тохиолдолд реактив буюу хүсэлт шаардлага ирэхэд нь хариулт үзүүлсэн байдалтай байгааг өөрчилж, проактив буюу илүү иргэн төр дээр очиж үйлчилгээ авахаас илүү төр нь иргэндээ очиж үйлчилгээ үзүүлдэг ийм сэтгэлгээний хандлагын өөрчлөлт орох шаардлагатай гэж үзээд байгаа. Ер нь энэ хиймэл оюуны эрин зуунд энэ төрийн үйлчилгээ бүтээмжийн чиглэлд трансформатив буюу бүр хувьсгалд эрс өөрчлөлтүүд гарах ийм прогноз тооцоолол явж байгаа. Тэгээд тэр энэ хандлага чиглэлийг буулгаж орчуулахад яг бизнес гэдэг шиг нэлээд нийтлэгээр хэрэглээд явж байгаа учраас тийм үг оруулсан юм. Бусад асуудлуудыг холбогдох яамнууд Сангийн яам хариулах байх.

Ц.Даваасүрэн: Ганбат хариулах юм уу. Сангийн яам хариулна гээд байна шүү дээ. 8 номер. Нэлээн хэд хэдэн асуулт асууна лээ шүү дээ. 4.

И.Батхүү: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Энэ банкны салбар дээр реформ хийх шаардлагатай тухай нэлээн хэдэн жил яригдаад, тодорхой хууль тогтоомжууд өөрчлөгдөөд бодит хэрэгжилт нь жоохон хоцрогдолтой байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө гэдэг бол нэг талаасаа богино хугацааны бодлогын баримт бичиг боловч бас тухайн салбарт хэрэгжүүлэх шаардлагатай реформын асуудлуудыг тусгаж өгч, салбарын яам холбогдох байгууллагууд энэ чиглэлээр

илүү их ажлууд хийгээсэй гэсэн бас хөшүүргийн үүрэг гүйцэтгэдэг юм. Улсын Их Хурал бол батлагдаж заавал хэрэгжүүлэх ажил болдог учраас.

Гадаадын хөрөнгө оруулалттай банкны хувьд Монгол Улсад бол оруулж ирэх 2, 3 арга байгаа.

1 дүгээрт нь бол өөрийн бүрэн эзэмшилтэй төлөөлөгчийн газар салбар банкаа байгуулах,

2 дугаарт нь бол одоо дотоодын арилжааны банкнуудаас хувьцаа эзэмших замаар хөрөнгө оруулалт хийх боломжууд бий. Үүнтэй холбоотой хууль, эрх зүйн орчин нь бүрдэж байгаа боловч бодитой хэрэгжилт нь сул байгаа гэдэг учраас энэ дээр тусгаж оруулж байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк орж ирснээр банкны салбарт .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 4 номерыг дахиад өгчихье.

И.Батхүү: Гадаадын хөрөнгө оруулалттай банк орж ирснээр банкны салбарт өрсөлдөөн нэмэгдэнэ. Таны түрүүн дурдсан цахим хэлбэрийн банк гэдэг нь одоо хэлээд байгаа гар утасны аппликэйшнээс илүү яг салбар төлөөлөгчийн нэгжүүдгүй бүрэн үйл ажиллагаа нь цахим хэлбэрийн банкнууд бас гаднын улс орнуудад орчхоод байгаа юм. Одоо банкны хүүг бууруулах дээр хүүгийн өртөг энэ дээр бол бас үйл ажиллагааны зардал их яригддаг. Энийг бууруулах бас нэг бодитой арга хэмжээ бол Цахим банк байгаа. Энэ тал дээр бас хувийн хэвшлийн шинэ хөрөнгө оруулагчдыг оруулах боломжийг нээж өгөх нь зүйтэй гэсэн үүднээс энэ асуудлыг тавьсан байгаа.

Тэгээд ЖДҮ-ийн тухайн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой ашиг сонирхлын янз бүрийн хэрэг байвал тэрийг нь тухайн хуулийн байгууллагууд нь шалгаад явах нь зөв байх.

Ц.Даваасүрэн: Болсон уу. Дутуу байна гээд байна. Сангийн яамтай холбогдолтойг нь та хэд хариулах юм уу. Дутуу байна гээд байна шүү дээ. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр гэсэн асуултууд. 9.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэдэг бол эдийн засгийн ангилал байгаад байгаа. Төсвийг нөгөө хүнийг бол олон янзаар нь ангилж болдог шиг эрэгтэй, эмэгтэй, нас, хүйсээр нь төсвийн нэг талаас нь л харж байгаа зүйл байгаад байгаа юм. Нөгөө тал нь бол юу вэ гэхээр зориулалтаар нь бид нар ангилж харж байгаа. Дараагийн ээлжид бол төсвийн ерөнхийлөн захирагчаар нь, газрын байршлаар нь, хаана хэрэгжүүлж байгаа гэдэг байдлаар харж байгаа.

Сая бол энэ жилийн төсвийг батлахдаа Их Хурлаас бид нарт бол тодорхой чиглэл өгсөн. Яг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ дээр бол анализ хийгээд, илүү тодорхой болгох чиглэл өгсний дагуу намрын төсөв дээр бид нар энэ эдийн засгийн ангилал дээр байгаа зардлуудыг яг хувийн хэвшил рүү чиглэсэн байдлаар нь зориулалтыг нь тодорхой болгож оруулж ирэх тийм төлөвлөгөөтэй байгаа.

Ц.Даваасүрэн: Тодруулах юм уу. Тодруулъя. Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Эдийн засаг, хөгжлийн яам зүгээр төлөвлөгөө гээд бичиж орж ирдэг. Тэгээд тэрэндээ таарсан ийм танин мэдэхүйн хариултууд хэлэхээ болимоор байгаа юм. Уг нь тодорхой асуугаад байгаа юм.

Шинэ үүсвэрүүдийг бүрдүүлнэ. Үйлдвэрлэлийн салбарт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гээд энэ дээрээ яг тодорхой ямар ажил хийхээр төлөвлөчихсөн байгаа юм. Тэрийг чинь асуугаад байгаа юм. Тэгээд тэр гаднын банк яг ямар банк орж ирэх гээд байгаа юм. 2026 онд хийх ажлын төлөвлөгөөг л яриад байгаа болохоос бид нар лоозон яриагүй шүү дээ. Гаднын банк орж ирэхээр ямар ач холбогдолтойг би бол мэдэж байна. Би энэ ач холбогдлыг нь бас асуугаагүй юм. Яг ямар банк орж ирэх гэж байгаа юм бэ. Яг ямар үйл ажиллагааг нь дэмжиж орж ирэх юм бэ. Аль улсынх юм бэ.

Сангийн яам ч гэсэндээ бид нар 2026 онд санхүү дээрээ одоо юу гэдэг юм тавилга, эд хогшил авмааргүй байна. Бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил, үйлчилгээ энэ тэр гэж урсгал зардлаа нэммээргүй байна. Энэ дээр яг тодорхой тоотой юмнууд байгаа юу л гэж асуусан юм.

Ц.Даваасүрэн: Ер нь бас тодорхой. Жишээлбэл дандаа л манайхан хүүгийн зардал бууруулна, гаднын банк оруулж ирнэ гээд л өмнөх юмаа хуулаад бичээд байгаа юм шиг л юм тавьчихаад байна л даа. Тэгээд энэ гишүүдийн хэлээд байгаа үнэн шүү. Нэг гоё төлөвлөгөө жил бүр л баталдаг. Тэгээд тэрний гүйцэтгэл ч гэж юм байхгүй гээд үнэн шүү дээ. Тэгээд та нар ч нэг юм оруулж ирдэг. Бид нар ч нэг юм баталмаар болдог. Нэг ийм л юм яваад байна шүү дээ. Тэгээд тодорхой хариул гээд байна. 4 номер тэр саяын банкны асуудал дээр.

И.Батхүү: Яг арилжааны банкны зөвшөөрөл олгохтой холбоотой асуудал нь бол Монголбанк дээр явагддаг. Тэр хүсэлтүүд нь ирээд, тодорхой журам шалгуур ...

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, үгүй. Тавьсан юм байна шүү дээ. Тэгээд ямар банк орж ирэх болчихоод та нар энэ хэдхэн сарын дараа байна шүү дээ. Огт байхгүй юм тавьчихаад байгаа юм уу. Ийм магадлалтай байгаа учраас тавиад байгаа юм уу гээд байна шүү дээ. Юун Монголбанк руу чихээд суугаад байгаа юм бэ чи одоо.

И.Батхүү: Түрүүн дурдсан энэ нөгөө жилийн хөгжлийн төлөвлөгөө маань хэрэгжүүлэхийн төлөө бас холбогдох байгууллагуудыг шахаж өгч байгаа Засгийн газрын бас чиглэл гэж бас харах хэрэгтэй. Яг тодорхой банкны нэр гэх юм бол Европын хөрөнгө оруулалтын банкны зүгээс төлөөлөгчийн газраа нээе гээд олон талт банк ажиллаж байгаа. Бас Францын хөгжлийн банкны салбар бас нээгдье гэсэн хүсэлтээ ирүүлээд ажиллаж байгаа. Энэ олон улсын хөгжлийн банкнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд бол олон талт гишүүнчлэлтэй банкнууд бас Засгийн газрын зээллэг гэхээсээ илүү хувийн хэвшилд илүү их санхүүжилт олгох талаар нь бас бид нар уулзалт болгондоо ярьж байгаа. Яг протоколыг нь харах юм бол Азийн хөгжлийн банк, и би ар ди айф центрийн хувийн хэвшилд олгож байгаа зээлийн хэмжээ бас нэмэгдэж байгаа. Тухайн зээлийн бас өртөг нь бага, урт хугацаатай байдаг.

Ц.Даваасүрэн: Энэ төлөвлөгөөнүүд чинь урт хугацаатай, дунд хугацаатай жилийн төлөвлөгөө гэж байгаа. Жилийн төлөвлөгөө дээр тэр чиглэл байхгүй ээ. Чи битгий балай юм яриад бай. Жилийн төлөвлөгөө гэдэг чинь ирэх жил хэрэгжих юм ярина за юу. Тэрнээс биш чиглэл өгч байгаа юм биш. Тийм балай юм ярьж болохгүй шүү дээ. Одоо наадах чинь тэгээд төсвөө төлөвлөхдөө та нарын наадхыг чинь яг хэрэгжинэ гэж бид нар барьж төлөвлөж байгаа биз дээ. Ирэх жилийн төсөв батлахдаа. Төлөвлөхдөө. Жишээлбэл төсөв төлөвлөхдөө чиглэл өгч байгаа юм гээд суугаад байх уу. Жилийн төсвийг. Та нар бас жоохон хариуцлагатай хандмаар байна шүү. Жилийн төлөвлөгөө шүү дээ энэ чинь. Жилийн төлөвлөгөө ирэх жил хэрэгжих арга хэмжээнүүдийн жагсаалт гэсэн үг. Сангийн яам тэр дутуу юмнуудаа хариул. 9 номерын микрофон.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Цогтбаатар гишүүний хэлж байгаатай бол санал 1 байна. Төлөвлөгөө дээр юу гэж орж байгаа гэхээр урсгал зардлыг 24 хувьд барина. Орон тоог бол 9 хувиар бууруулна ч гэдэг юм уу ийм байдлаар шууд механикаар явж байгаа. Яг таны хэлж байгаатай санал 1 байна. Одоо зүгээр юу гэдэг юм тавилга, эд хогшлыг авахгүй ч гэдэг юм уу ийм механик байдлаар бол бид нар хийгээд ийм хэмжээний зардал гаргаж чадахгүй л дээ. Тэгэхээр төлөвлөгөө бидэнд хэрэгтэй. Тэр нь бид нар юу гэж харж байгаа вэ гэхлээр чиг үүргийн шинжилгээг бол бүрэн хэмжээнд хийгээд, ийм байдлаар төр өөрөө зайлшгүй хийх шаардлагагүй ажлуудаа хувийн хэвшилд гаргах замаар л энийг бүтцийн маш том өөрчлөлтийн асуудал хийж байж л оруулж ирэх боломжтой гэж харж байгаа. Механикаар бол ийм үүрэг аваад, бид нар бол шууд хийхэд бол хүнд байх.

Ц.Даваасүрэн: Тийм тийм. Ер нь зүгээр бид нар бараа бүтээгдэхүүн янз бүрийн юмны үнэ 2 дахин өсчихлөө гээд байгаа мөртөө төсөв чинь өөрөө 3 дахин өсчхөөд байгаа байхгүй юу энэ хугацаанд. Тэгээд энэ 3 дахин өсөлт хаашаа оров гэдгийг бид нар их сайн анализ хийж үзэх хэрэгтэй. Тэгээд тэрийгээ яаж өөрчлөх вэ гэдэг л төсвийн шинэчлэлт, реформын юм хийхгүй бол нэгэнт өсгөчихсөн төсвийг механикаар буулгана тэдэн хувь, тэдэн хувь гэдэг юм байхгүй шүү дээ. Хэцүү. Энэ чинь орон тоог бол зүгээр бид нар төсөв батлахдаа хэдэн тэрбумаар нэмээд батлаад өгчхөж байна шүү дээ. Тэгэхээр энэ бүгдийг л жишээлбэл яаж цөөлөх юм, ямар салбараар багасгах юм, яамдынхаа тоог 20 болгочихсоноо яах юм энэ тэр гэдэг юмнуудыг ярьж нэлээн том бүтцийн шинэчлэлтийн юм хийж байж энэ төсөв бууруулна уу гэхээс биш. Тэгээд яах вэ та нар л яг л нөгөө өмнө нь бичдэгээ л бичиж байгаа байхгүй юу. 1 л гоё үгнүүддээ. Хэрэглээд сурчихсан. Байнга тэрийгээ хэрэглэдэг. Төсвийн урсгал зардлыг бууруулна. Тэдэн хувь гээд л. Эдийн засгийн тэдээр өсгөнө, тэдэн хувь гээд л. Тэгээд төлөвлөгөө бодитой биш байгаад л асуудал байгаад байх шиг байгаа юм. Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Өглөөний мэнд хүргэе. Өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг дээр хэд хэдэн асуулт асуучихсан. Тэрэнтэйгээ холбоотой 2 тодорхой асуулт асуугаадахъя.

Энэ хөгжлийн төлөвлөгөөнд тусаж байгаа арга хэмжээ бол ер нь 2026 оны төсөвт тусагдаад орж ирнэ гэж ойлгоод байгаа. Ер нь бол тэгэх ёстой. Төлөвлөгөө гэдэг маань тийм л байх гэж ойлгож байна. Тэгэхээр энэ санхүүжих дүн хэт ялгаатай зүйлүүд харагдаад байгаа энэ дээр. Тэгээд ялангуяа энэ зээлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд дээр санхүүжих дүн нь бол улсын төсвөөр хэрэгжиж байгаа төсвөөсөө арай л ялгаатай харагдаад байдаг. Тэгэхээр та нар

энийг төсөвт тусгаж оруулж ирэхдээ санхүүжих дүнтэй нь уялдуулаад төслийн үр өгөөж, тоо хэмжээг нь нэмэгдүүлэх байдлаар ч юм уу засварлаад оруулж ирэх боломж байгаа юу гэдэг эхний асуулт. Сангийн яам, Эдийн засгийн яам 2 өчигдөр би бас ажлын хэсэг дээр хэлсэн. Энэ 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь бид нар чинь хуулиараа төсөв хэлэлцээд, төсөвт тусгах төсөл арга хэмжээг заавал ч үгүй зураг төсөл, ТЭЗҮ-тэй байх ёстой гээд заачихсан байгаад байдаг. Үүгээрээ төсөвт тусгаад байдаг. Ер нь сүүлийн үед зургийн үнэ ТЭЗҮ зохиох гэдэг юмаар ер нь мөнгө нэлээн цохидог болчихсон юм уу даа гэж харагдаад байгаа юм. Одоо 1 цэцэрлэг, сургуулийн мөнгөөр цохидог байсан одоо сүүлдээ бүр болиод 14 мега төсөл гэж оруулж ирээд, энэ чинь 380 орчим тэрбум төгрөгөөр бид нар зүгээр ТЭЗҮ, зураг төсөл хийлгэж байгаа шүү дээ.

Тэгээд тэр нь цаасан дээр үлдээд байдаг. Энэ нэг дүүжин гүүр, Богд уулын нүхэн гарц гээд хэрэгжих ч юм уу, үгүй ч юм уу. Энэ дээр л лав 40 орчим тэрбум 40, 50-иараа л явж байгаа байх. Нийслэл гэхэд чинь энэ тойрог замын ТЭЗҮ хийлгэнэ гээд замынхаа өртгөөс өндөр үнэтэй ТЭЗҮ хийлгээд гээд байгаа шүү дээ. 1,3 тэрбумаар ТЭЗҮ хийлгээд явж байгаа шүү дээ. Зөвхөн зураг төсөл, ТЭЗҮ нь.

Гэтэл улсын төсөв дээр тусаж байгаа энэ төлөвлөгөө дээр байгаа зам нь өөрөө 1,1-ээр барина гээд ороод ирчихсэн байж байдаг. Тэрнээсээ илүү үнэтэй ийм ТЭЗҮ зохиолгоод явж байгаа нийслэл бас байж л байгаа. Өчигдөр энэ 2025 онд төсвөөс хасагдсан барилга байгууламжийн жагсаалтыг бас бид нарт ажлын хэсэгт өгсөн юм. Энэ дээр нийт санхүүжих төсөвт өртөг нь 2,2 их наяд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрийнх нь зураг төсөв, ТЭЗҮ-ийнх нь үнэ нь хэд юм бэ. Ер нь бид нар энэ оруулж чадахгүй байгаа яг хууль хэрэгжсэнээс хойш баахан зураг төсөв хийчхээд, тэгээд тэр нь төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй. Ингээд баахан ТЭЗҮ-д зурганд мөнгө зарчихсан, хэрэгжээгүй энэ төслийнх нь нийт зардал нь хэд болчихоод байгаа юм бэ гэдгийг асуумаар байх юм. Одоо энэ чинь 2205 онд ороогүй, 2026 онд дахиад энэ нь тусаагүй. Байхгүй энэ дотор. Тэгээд 2027 он болохоор дахиад л нэг магадлал хийгээд, ТЭЗҮ-г нь дахиад шинэчлэх ажил болдог. Эсвэл үнэ дээр нь өөрчлөлт оруулна гээд явчихдаг. Энэ ер нь яг хэчнээн төгрөг байгаа вэ. Одоо хэрэгжээгүй баахан арга хэмжээний зурагт зарчихсан мөнгө нь өөрөө. Энийг асуумаар байна.

Ц.Даваасүрэн: 2 номерын микрофон хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Өчигдөр ажлын хэсэг дээр Батболд гишүүн бас энэ асуултыг асуусан. Тэгээд бид Эрчим хүчний яамтай хамт урд шөнө суугаад бүх тоонуудаа нягталсан. Ер нь бол бид яамнуудтай тоонуудаа нэлээн хэд хэд уулзалтаар нягталсан боловч бас энэ дээр Эрчим хүчний яамнаас алдаа гарсан байна. Тухайлбал тэр Бөөрөлжүүт, Сэргэлэн чиглэлийн 88км агаарын дамжуулах шугамын өртөг болон Өмнөговь чиглэлийн. Тэгээд өнөөдөр 10 цагаас ажлын хэсэгтэйгээ хамт бусад яамнуудыг дуудаад ахиж тоон дээрээ нягтлахаар бид нар ажиллаж байна. Таны өчигдрийн асуусан агаарын шугам дээр бол Эрчим хүчний яамнаас тооцооллоо буруу хийсэн учраас ажлын хэсэг дээр энийг засахаар ярьж байгаа.

Ц.Даваасүрэн: Та нар төрийн эрх барих дээд байгууллага Их Хуралдаа оруулсан юм шүү дээ. Тэгээд тэр нь алдаатай байна лээ гээд. Тэгээд одоо алдааг нь засна гээд. Тэгээд нөгөөдүүл нь батлах гээд сууж байдаг 2 тохирч байгаа юм уу.

Алдаатай юм оруулж ирж болдог юм уу. Тэгээд та нарыг наадхаа засаж амжаагүй байхад чинь бид нар батлаад л явах нь байна шүү дээ. Бусад асуултад нь хариулъя. Төсөвтэй холбогдолтой юм асуугаад байсан уу, үгүй юу Батболдоо, Батболдын микрофоныг өгье дөө.

Р.Батболд: Энэ зураг төсөвтэй холбоотой асуулт асуугаад байгаа юм. Зураг төсөв хийлгэхээд, тэр нь хэрэгжээгүй. Тэгээд тэр зураг төсөв нь хогийн саванд орохоор болчихсон. Тэрэнд ер нь хэдэн төгрөг зарчихсан юм бэ л гэж асуугаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам. Ер нь байна шүү одоо янз бүрийн юмнуудын зураг төсөв, ТЭЗҮ хийхэд хэдэн тэрбумаараа яриад байгаа байхгүй юу. Энэ юу болоод байгааг бас ажлын хэсэг гаргаж, шалгах ч ийм шаардлага байж магадгүй. Тэгээд 10, 20 тэрбумаар зураг, ТЭЗҮ хийгдсэн мөртөө нөгөөдөх нь ажил нь хийгдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэрийг асуугаад байна. Эдийн засаг, хөгжлийн яам хариулъя. 4 үү. Танайх чинь ТЭЗҮ хариуцаад байгаа юм байна лээ шүү дээ.

И.Батхүү: Батболд гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайдын багц дээр бол 20 тэрбум төгрөгийн ТЭЗҮ-ийн төсөв суусан. Энэ дээрээ сайдын шийдвэрээр задаргаа төслүүдийнх нь жагсаалт гараад, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээд, тэнд худалдан авалтад зохион байгуулаад, гэрээ байгуулна.

Ц.Даваасүрэн: Тэрийг чинь ойлгоод байгаа байхгүй юу. Жишээлбэл яагаад ТЭЗҮ хийх, зураг хийх үнэ өртөг нь харьцангуй өндөр болчихсон бэ энэ сүүлийн 2, 3 жилийн хугацаанд л гэж асуугаад байна шүү дээ. Тэрийг л хариул л даа. Хаашаа очдог вэ, хэн хийдэг вэ, тэрийг чинь бүгд мэдэж байгаа. Жишээлбэл аргачлалаа өөрчилж болно шүү дээ. Магадгүй үнийг тогтоохдоо гадаадын оронд дийлэнх нь тендерээр тогтоогоод байдаг юм байна шүү дээ. Зургийг чи хэдээр хийх юм бэ гэж. Тэрнээс биш нөгөө яг ажлын хөлс шиг тогтоогоод өгчихдөггүй юм байна. Тэгэхээр чинь бас асуудал үүсээд байгаа байхгүй юу. Та нар ямар аргачлалаар энэ төсвөө хянаад байгаа юм бэ гээд байна шүү дээ. 4 номер.

И.Батхүү: Энэ ТЭЗҮ-ийн зардал бол нийслэл, Зам тээврийн яам гээд бусад сайд нарын багц дээр бас том дүнтэй байгаа. Тэр дээрээ задаргаа нь бас явагдаж байгаа. Гол нь яг мэргэжлийн захиалагч яам маань өөрөө ажлын даалгавар, тухайн арга хэмжээний төсөвт өртгийг ирүүлж байгаа юм. Тэрнийх нь дагуу сайдын тушаалын төсөлд ороод жагсаалтаар батлагдаж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, би чинь 2 удаа сайд хийсэн. Тэгэхэд надаас лав энэ хэдээр хийгдэх юм бэ гэдэг ч юм уу, би тийм юм баталж ер нь явуулаагүй шүү дээ танайх руу. Танайх руу би юу явуулсан гэхээр ийм ийм хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг төсөвт тусгаж шийдэж өгөөч ээ л гэж явуулсан. Тэгээд л та нар л үнэ өртгийг нь тогтоосон шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яам өмнө нь. Яагаад худлаа хариулаад байгаа юм. Тэрнээс биш би л лав тэдээр гэж ерөөсөө явуулаагүй. Би хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр ярьж байна шүү. Жишээлбэл Барилгын хөгжлийн яамны явуулж байгаа. 4 номер. Яагаад худлаа хариулаад, чи ер нь ерөнхий худлаа хариулаад байх юм.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад тусгагдсан ТЭЗҮ-ийн зардлыг задлахтай холбоотой яамнуудаас ирсэн сайд нарын гарын үсэгтэй албан бичгүүд, тэр мэдээллийг хүргүүлж болно.

Ц.Даваасүрэн: Тэр чинь нэр л ирж байгаа шүү дээ.

И.Батхүү: Тэрийг хүргүүлж болно.

Ц.Даваасүрэн: Тэрийг нь яаж, ямар аргачлалаар тогтоогоод байгаа юм бэ гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэрийг нь яаж та нар тогтоогоод байгаа юм. Жишээлбэл 1 сумын хөгжлийн төлөвлөгөө хийхэд тэдэн төгрөг, 200 сая, 100 сая гээд хийгээд байна шүү дээ танайхан. Тэрийгээ яаж ямар аргачлалаар төсвийг нь гаргаж ирээд байгаа юм бэ гээд байна шүү дээ. 4 номер.

И.Батхүү: Сая дурдсан салбарын яамдаас ирсэн хүсэлт дээрээ төсөвт өртөгтэйгөө хамт ирж байгаа. Тухайн ажлын тодорхойлолт. Би тэр албан бичгүүдийг танд хүргүүлье. Яамнуудаас ирсэн.

Ц.Даваасүрэн: Батболд.

Р.Батболд: Асуултын маань бас жоохон агуулга нь өөрчлөгдчих гээд байна. Би нэг баахан цаас үйлдвэрлэчихсэн. Үүнийхээ хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнийхээ ТЭЗҮ, зурагт нь хэдэн төгрөг зарчихсан байгаа вэ л гэж асуугаад байгаа юм. Энийг нэгтгэдэг болохоор уг нь Сангийн яам хариулчихвал их зүгээр байгаа юм. Сангийн яам дээр байхгүй бол энийг нэгтгээд гаргаж өгөөч гэдэг нэг асуудал байгаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Одоо Эдийн засаг, хөгжлийн яаман дээр хийгдсэн зураг төсөв, ТЭЗҮ-ийн хэдэн хувь нь хэрэгжсэн юм бэ. Хэдэн хувь нь хэрэгжээгүй юм бэ. 8 Ганбат.

Ж.Ганбат: Өнгөрсөн 2024 онд ТЭЗҮ, зураг төсөв хийнэ гээд Улсын Их Хурлаар батлагдсан хууль дээр 316 тэрбум төгрөг зураг төсөвт батлагдсан. Үүнээс 40 тэрбум төгрөг нь Эдийн засаг, хөгжлийн яаман дээр батлагдсан. Гүйцэтгэлээр 287 тэрбум төгрөгийг ТЭЗҮ, зураг төсөвт зарсан гэдэг ийм 2024 оны гүйцэтгэл бол байна. Энэ 2025 оны төсөв дээр Эдийн засаг, хөгжлийн яам дээр зураг, ТЭЗҮ хийхэд зориулагдан бас 20 тэрбум төгрөг Эдийн засаг, хөгжлийн сайдын багц дээр батлагдсан байгаа.

Ц.Даваасүрэн: Одоо болчихсон. 2 тодруулаад болчихож байгаа байхгүй юу. Дэг зөрчмөөргүй байна. Уучлаарай. Би 2 тодруулчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр 3 дахь гэж байхгүй.

Зарчмын зөрүүтэй санал хураалт. Та нар яг асуусан асуултад сая бол ингэж асуусан байхгүй юу. ТЭЗҮ, зураг төсөв хийгдэж байна. Эдийн засаг, хөгжлийн яаман дээр. Тэрнээс дийлэнх нь хэрэгжихгүй байна. Ямар, ямар төслүүд хэрэгжсэнгүй вэ гэж асуусан байхгүй юу. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл хэлэлцэж байгаа юм бид хэд. Тэр төсвийн орлого, зарлага, тэнцэл энэ тэрийн тоон үзүүлэлтийг бол дараагийн хэлэлцэх асуудал

дээр нь ярья. Энэ дээр 2, 3 зүйл байгаад байна. Богино хугацаанд хэрэгжиж байгаа төлөвлөгөө учраас хэдүүлээ нэлээн бодитой үр дүн харж, яг хийж хэрэгжүүлэх ажил талынхаа юмыг хармаар байна л даа. Тэгээд бас цаг үе чинь өөрөө энэ эдийн засаг чинь гадаад, дотоод нөхцөл байдлаасаа хамаараад тийм нэлээн төлөвлөж байсан гэдэг юм уу, бодож байсан хэмжээнээс жоохон агшин мөнгөтэй л байгаад байна шүү дээ. Тэгэхээр үүнийгээ харж тооцож, үүнийхээ эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө маягтайгаар бараг л гармаар санагдаад байгаа юм миний бодож байгаагаар бол. Тэгээд бас эрэмбэлэх хэрэгтэй байна. Угаасаа цаг хугацаа ч тэр, санхүүгийн нөөц ч тэр, хязгаарлагдмал байгаа учраас үнэхээрийн энэ улс орны хөгжилд гэдэг юм уу, эдийн засгийн идэвхжил, эргэлтэд нь хэрэгтэй зүйлээ эхэлж олж харж, тэр лүүгээ хөрөнгөө чиглүүлэх нь зайлшгүй шаардлага байгаад байна.

Тэгэхээр эдийн засгийн коридоруудын тухай хэдүүлээ ярьсан байгаа юм энэ төлөвлөгөөнд. Энэ үндсэн коридороо нэг жоохон идэвхжүүлмээр байх юм. Сэлэнгийн Алтанбулагаас Дорноговийн Замын-Үүд хүртэлх энэ коридороо жоохон идэвхжүүлмээр байдаг. Энэ рүүгээ бодлогоор хөрөнгөө чиглүүлмээр байдаг. Гадаад, дотоодын татаж болох эх үүсвэрүүдээ үүнтэйгээ уялдуулж тэр зах зээлийнх нь багтаамж, орон зайн ашигтай байршил, энэ бүх юмаа харгалзаад терминал агуулахынхаа юмыг шийдмээр байдаг. Үүнтэйгээ дөхүүлж тэр хөнгөн, хүнд, хүнсний үйлдвэрүүдийнхээ үйлдвэр технологийн паркуудыг хиймээр байдаг. Энэ тал дээр ер нь та хэд цогцоор нь харж төлөвлөөд байгаа юм юу байгаад байгаа юм бэ. Ерөнхий өгүүлбэрээр хийчихдэг. Яг ажил нь явах гэхээр зэрэг тэнд нэг боомтын асуудал яриад, түүгээрээ асуудал хаагдчихаад ерөөсөө болж өгөхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ юмаа ер нь яая гэж бодоод байна вэ гэж 1 ийм зүйл.

2 дахь зүйл бий болгочихсон хүчин чадлуудаа ашиглалтыг нь нэмэгдүүлж байж энэ эдийн засгийнхаа идэвхжил, тэгээд үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр энэ бүх юмаа хангамаар байгаад байгаа юм. Хүнсний үйлдвэр гээд л ярихаар гурилын үйлдвэрүүдийн чинь хүчин чадал, ашиглалт 20 орчим хувьтай байна. Уул уурхай ярихаар зэрэг угаадаг баяжуулдаг чинь нэлээн хэдэн зогссон байна. Тэгэхээр үүнийг хэдүүлээ яаж идэвхжүүлж өгөх юм бэ. 2026 оны төлөвлөгөөнд бол ийм л юмнууд ормоор байна. Тэр хувийн хөрөнгөөр баахан хүмүүс юм барьчихаад байна. Тэрийг нь ажилладаг болгоод гарч ирж байгаа тэр олборлосон бүтээгдэхүүнүүдийг нь тодорхой хэмжээний чанарыг нь тордолтыг нь хийгээд үнэ цэн оруулаад гаргачихмаар л байна л даа. Ингэж байж л Монголын энэ экспорт гэдэг юм уу, валют дотогшлуулах үйл явц чинь нэмэгдмээр санагдаад байх юм. Энэ рүүгээ ер нь ямар төсөөлөл юу бодоод байна. Ямар эрх зүйн орчин бүрдүүлье гэж хараад байна. 2026 оноос өмнө эрх зүйн орчноо бүрдүүлээд, 2026 он гэхэд бүтэн хүчин чадлаараа ажиллачих хэмжээний ийм тооцоолол юмнуудыг ер нь ямархуу байдлаар хараад байгаа юм бэ гэдэг нэг ийм зүйл байна. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч ээ гэж. Нэг ийм зүйл хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл хэдүүлээ татварын орчноо сайжруулъя. Юм хийж бүтээдэг бас ахиухан дэмждэг тийм бололцоо боломжийг нь бүрдүүлье гээд ажлын хэсэг гээд баахан юм байгуулчихсан. Үүнийгээ .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам хариулъя. 4. Тодорхой хариулаарай.

И.Батхүү: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн коридорын төслүүдийн хувьд 2015 онд батлагдсан 32 төслийн жагсаалт байдаг. Энэ төслийн хэрэгжилтийг сайжруулах талаар 3 улсын хамтарсан ажлын хэсэг бас өнгөрсөн онд энэ хэрэгжилтийг нь дүгнээд, хэрэгжих боломжтой, боломжгүй, тодорхой ахиц гарсан гэдэг дээр нь бүгдээрээ хамтарч ажиллаад, шинэчлэн жагсаалт 33 төслөөр баталсан байгаа. Энэ төслүүдийг хэрэгжүүлэх талаар ялангуяа Зам, тээврийн яам, энэ эдийн засгийн коридор маань зөвхөн дэд бүтцийн төслүүд биш бас нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээнд бас орчихсон байгаа. Боловсролын яам, бусад яамнууд ажиллаад, 2 хөрш улсын холбогдох байгууллагуудтай энэ тал дээр ажлын хэсэг гараад, хэрэгжилтийг нь сайжруулах талаар ажиллаж байгаа. Тантай санал нэг байна. Яг энэ эдийн засгийн коридорын ач холбогдол бол транзит тээврээс гадна бас Монгол Улсын экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлийн ажлууд байгаа.

Таны дурдсан төв коридорын асуудал бол Зам, тээврийн яам дээр бас холбогдох улсын байгууллагуудтай яг энэ чиглэлээр ажиллаад, тодорхой төслийн саналууд ярилцаад явж байгаа. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах тал дээр энэ яригдаад байгаа улсын хөгжлийн төлөвлөгөө маань зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт биш төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын томоохон улс орны хэмжээнд ач холбогдол үзүүлэх төслүүдийг бас оруулдаг. Энэ чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яам дээр бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулаад хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар ажиллаж байгаа. Мөн Хөрөнгө оруулалтын тухай хуулийг бас шинэчилсэн найруулгыг бас бэлдээд ажиллаж байна. Ойрын хугацаанд Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байгаа. Энэ 2 хууль маань гол хувийн хэвшил төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийг маань эрх зүйн хувьд бас хурдтай, үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Ц.Даваасүрэн: 3 дахь асуулт нь тэр суурилагдсан хүчин чадлуудаа яах гээд байгаа юм гээд байна. Энийгээ хөгжүүлээд явдаггүй юм уу гээд. Хэн хариулах юм. Хариулт байхгүй юу. 2.

Ц.Эрдэнэбат: Тэгээд эдийн засгийн коридорын чиглэл дээр анхаарч байгаа. Тэгээд энэ чиглэлээр ахиад дурдвал Дархан хот Алтанбулагийн чиглэлийн зам, Алтанбулаг чөлөөт бүсийн гааль, теле хяналтын нэгдсэн систем Замын-Үүдэд зорчигч тээврийн буудал, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл, Хүннү хотоос Замын-Үүд чиглэлийн зам гэх мэтчилний төслүүд орсон байгаа. Яг тэр үйлдвэрүүдийн тухайд бол нөгөө Засгийн газрын өргөтгөсөн хурал бүсчилсэн хөгжлийн хүрээнд үзэл баримтлалын хүрээнд энэ хурлууд явагдаж байгаа. Энэ үеүдээр нэлээн саналууд гарч ирж байгаа. Эхнээсээ Засгийн газрын тогтоол шийдвэрүүд нь гараад явж байгаа. Тэгээд энэ дээр орон нутгийн зүгээс нэлээд бас гарч байгаа саналууд нь тэр үйлдвэрлэл, бүтээн байгуулалт дээр нэлээд анхаарч ажиллахаар явж байгаа. Тэгэхээр тэр бүсүүд маань ирэх 7 хоногт энэ төвийн бүс Дарханд болонгуут.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн тодруулъя. Яах вэ энэ гишүүд тодруул гээд байгаа дээр энэ Эдийн засаг, хөгжлийн яам чинь байна шүү дээ Эдийн засагч нараар бүрдчихээд байгаа байхгүй юу. Тухайн салбарын хүмүүс тэнд төлөвлөлт хийхгүй байгаа байхгүй юу даа. Замын мэргэжилтэн гэдэг юм уу, замын инженер төлөвлөлтийн хүмүүс, аль эсвэл эрчим хүчний гэдэг юм уу, Хөдөө аж ахуйн хүмүүс

тэнд байхгүй байхгүй юу. Тийм учраас та нарын асуугаад байгаа юм зүгээр л нэг тоо төдий эдийн засгийн санхүүгийн үзүүлэлт төдий л хариулчхаад байна л даа. Батжаргал гишүүн. Уг нь төлөвлөлтийн яам гэдэг чинь жинхэнэ салбарын мэргэжлийн шилдэг хүмүүс тухайн салбар бүрээс очиж байж боловсролын хүн байж байж, замын хүн байж байж тэгж байж төлөвлөлт хийгдэх ёстой байхгүй юу. Тэгээд яамаа байгуулж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэр эдийн засгийн коридор гээд л ярихаар 30 хэдэн төсөл байгаа энэ тэр гээд бидэнд тийм боломж одоогоор байхгүй байгаа. 3 үндсэн коридороо л хийе гэдэг юм руугаа бүх анхаарлаа чиглүүлмээр байгаа байхгүй юу. Үндсэн коридороо сайжруулж авъя. Баруун, зүүн 2 дээрээ тэр яригдаад байгаа 2 коридороо янзлаад авъя. Үүнийгээ дагасан хөгжлийн төлөвлөлт суурьшлуудаа бүгдийг нь тодорхой болгоод авъя. Тэгээд л тэр лүүгээ хөрөнгөө чиглүүлъя. Ерөөсөө бидний 2026 оны төлөвлөгөөнд гол анхаарал хандуулах ёстой зүйл бол энэ л байгаад байгаа юм. Ингэж байж л бид жоохон урагшилна. Угаасаа бидэнд мөнгө тийм хангалттай байхгүй байгаа юм чинь, байгаа мөнгөндөө гэдэг юм уу, гаднаас олж ирэх юмандаа тулгуурлаж ийм л юмаа барьж авч хиймээр байна гэдэг юмаа тодорхой болгомоор байна. Одоо ингээд цар хүрээг нь тэлчихсэн юм яриад хэдэн биеийгээ амыг нь таглаад, тэгээд олигтой үр дүн гаралгүй ингээд явамгүй байна.

Дараагийн нэг зүйл наад суурилагдсан хүчин чадлуудаа бүгдийг нь үзээд ямар арга хэмжээ .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батжаргалаар Эдийн засаг, хөгжлийн сайд хийвэл арай илүү болохоор байна шүү. Хариулт ч алга юм байна. Санал гэж ойлголоо. Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Би тодорхой 4 асуулт асууя даа. Тэгээд хариултаа их сайн хариулахгүй бол нэг л болохгүй л байна даа. Энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хараад л сууж байна. Тэр 8 дугаар зүйлд нь 2024 оны жилийн төлөвлөгөөний тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт нь 52,1 хувь гэсэн байх юм. Энэ чинь дөнгөж юм төлөвлөөд дөнгөж 52,1 хувь нь хэрэгжсэн юм бол үлдсэн ер нь бид нар чинь 100 хувь гэж бодоход 50 хувь нь хэрэгжээд байвал энэ чинь ер нь төлөвлөхийн хэрэг байна уу. Энэ шалтгаан нь юу юм. 52,1 хувь нь хэрэгжсэн гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэсэн байна. Ямар хүндрэл гарсан юм. Ямар шалтгаан байгаа юм. 1 дүгээр асуулт нь.

2 дугаар зүйл нь тэр оруулж ирж байгаа Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтийн 2 дугаар зүйл дээр бас санхүүжилт нь тодорхойгүй 24 төсөл, арга хэмжээ байгаа. Үүний дотор тэр байгалийн хийн хоолой барих төслийн бэлтгэл ажлыг хангах гэсэн байна. Энэ төсөл чинь саяхан Ялалтын баяраар урд хөршийн Ерөнхийлөгч хойно очихдоо энэ чинь манайхаар дамжуулахааргүй болчихсон биш үү. Ингээд гоё төслийн нэр яриад, тэгээд бэлтгэл хангадаг ажлын хэсэг гээд эсвэл ТЭЗҮ гээд нөгөө нэг гоё хоолны нэр хэлэв, би савхдав гэдэг шиг л юм яваад байх юм. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ. Наадах чинь манайхаар дамжихгүй болсон байх. Тэгээд тэр бэлтгэл хангана гээд оруулчихсан байгаа харагдах юма. Дахиад тэр 2 дугаар зүйл дээр нь 7,6 тэрбум төгрөгийн Хэрлэн-Тоонот усан цогцолбор төсөл гээд энэ юу вэ.

Дахиад 3 дахь асуулт нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 6 дугаар заалт дээр байгаа энэ Хэрлэн-Тооноттой холбоотой 2025 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр 17,9 тэрбум төгрөг. Энэ төслийн бэлтгэл ажлыг хангах. Энэ дээр юу хийгдэж байна. Одоо хагас жил өнгөрчхөж байна. Ийм 3 тодорхой асуулт байна.

Дээрээс нь сая 5 сарын 12-нд Говийн бүсийн зөвлөгөөн гээд манай Дорноговь аймагт чамгүй сайн зохион байгуулсан. Говийн бүсээс баахан хүмүүс авчраад зөндөө ажил ярьсан. Би өчигдөр ажлын хэсэг дээр энийг асуусан. Тодорхой хариулж чадахгүй байх шиг байна. Одоо эндээс гарсан Засгийн газрын шийдвэр энэ 2025 он, хагас жил болчихлоо. 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд сууж байх ёстой. Тэр Засгийн газрын тогтоолд орсон зүйлүүд ерөөсөө харагдахгүй байх юм. Энэ яах ёстой вэ Төрийн нарийн бичгийн дарга аа. Сайд нь байхгүй байна. Төрийн нарийнаас л асуух байх л даа. Энэ 4 асуулт дээр хариулт аваадахъя. Тэгээд тодруулъя.

Ц.Даваасүрэн: 4 номер хариулъя. 4 тодорхой асуулт байна.

И.Батхүү: Сүүлийн асуултад нь хариулъя. Бүсийн хөгжлийн өргөтгөсөн зөвлөгөөнүүд тодорхой хуваарь гаргаад, одоо үргэлжлээд яваад байгаа. Бид нар бас хуульд баригдсан цаглаврынхаа хүрээнд 1 сараас эхлээд салбарын яамдтай энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналаа хүлээж аваад, хамтарч ажиллаад нэлээн олон удаагийн уулзалт, үр дүнгийн талаар хамтарч ажиллаад энэ төслөө боловсруулсан байгаа. Төслөө бас Засгийн газрын хуралд танилцуулаад, хуулийн цаглаврын дагуу Улсын Их Хуралд өргөн барьсан. Яг одоо энэ үргэлжлээд явж байгаа бүсийн зөвлөгөөн дээр гарч байгаа шийдвэр, саналуудыг бол тусгах асуудлыг Улсын Их Хурлын өргөн барьчихсан учраас дэгийн дагуу шийдвэрлэх байх гэж бодож байна.

Өмнөх 3 асуудалтай холбоотой яг манай хариуцсан, яамнуудтайгаа сууж ажилласан газрын дарга хариулна.

Ц.Даваасүрэн: 2 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Хийн хоолойн төсөл бид нар энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний процесс маань 1 сараас эхэлсэн. Энэ үед бол бидэнд ирсэн. Зарим асуудал нь нууцын хүрээнд байдаг юм шиг байна лээ. Ирсэн мэдээллээр бол бүх төслийн бэлтгэл ажлууд нэлээд Монгол талаас хамаарах ажлууд нь хангагдсан. Гагцхүү хөрш орны холбоотой асуудлууд үлдсэн гэж ойлгогдсон. Энэ суурь судалгаа, ТЭЗҮ тэр хамгийн сүүлийн 1 судалгаанаас бусад нь бол хийгдсэн. Тэгэхээр энэ төсөл маань бэлэн байгаа. Ер нь бол бидний ойлголтоор бол энэ цаашаа явна гэж бодож ойлгож энэ төсөл явж байгаа.

2024 оны Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт 52 хувьтай гэдэг ч одоо бид яг тэр дээр нь дүгнэлтийг саяхан авсан. Яг нарийвчлаад судалгаа .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 2 номерын микрофоныг үргэлжлүүлээд өгчихье.

Ц.Эрдэнэбат: Тэгээд тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн асуулт, дүгнэлт бүрээр нь хариултаа бэлдээд өнөөдрийн дотор ажлын хэсэгт хүргүүлэхээр бид нар ажиллаж байна. Эхний хариултууд маань гараад ирчихсэн явж байгаа. Тэгэхээр өнөөдөр бид нар бичгээр ажлын хэсэгт хүргүүлнэ.

Ц.Даваасүрэн: Болсон уу. Тэр 27,9 тэрбумаар юу гэхихсэн юм гээд тодорхой тодорхой 2 асуулт байгаад байна шүү дээ. Тэр Хэрлэн, усан төсөл гээд байна. Хэн хариулах юм. 2. Тэмдэглэж аваад та нар бүгдэд нь хариул л даа.

Ц.Эрдэнэбат: Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ашиглах 100мвт-ын усан цэрэг цахилгаан станц гээд энэ олон улсын санхүүжилтээр хэрэгжихээр төсөл явж байгаа юм. Хэрлэн тооно Орхон өнгө гэсэн төслүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ч орсон. Энийг гарцаагүй хэрэгжүүлэх ёстой гэж явж байгаа. Бидэнд ирсэн мэдээллээр бол яг одоогийн байдлаар Хэрлэнгээс урагшаа Говь руу татах энэ усны төслийн ТЭЗҮ, судалгааны ажлыг Оюутолгойн хөрөнгө оруулалтаар яг одоо хийгдээд явж байгаа гэж ойлгосон. Тэгээд энэ хийгдээд маршрут юм нь тодорхой болж байж дараагийн ажлууд нь хийгдэнэ гэж. Энэ дээр бол Засгийн газрын түвшинд ажлын хэсэг гарчихсан ажиллаад явж байгаа.

Ц.Даваасүрэн: Хийгдээд явж байгаа гэж ойлгосон гэж байна шүү дээ. Сайн мэдэхгүй л байгаа юм байна л даа. Тэгээд л төлөвлөсөн юм байна. Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Ер нь тэр сая хийгдээд явж байгаа гэж ойлгосон гэж буруу шүү. Та нар Эдийн засаг, хөгжлийн яам. Энэ улс одоо хуучнаар бол Төлөвлөгөөний комисс шүү дээ та нар. Энэ улсын төлөвлөлтийг та нар хийж байгаа хүмүүс байхгүй юу. Бүх юмаа яг тодорхой хариулж байх ёстой. Мэдэж байх ёстой. Тэр Оюутолгойгоор ТЭЗҮ хийгдэж байгаа асуудал чинь бол тусдаа асуудал.

Миний асуугаад байгаа асуулт чинь болохоор 2025 онд төлөвлөсөн 2017 оны 17,9 тэрбумаар тэр 6 дугаар заалт буюу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлтийн 6 дугаар заалтыг би яриад байна л даа. 2017 оны 17,9 тэрбумаар яг юу хийж байна вэ гэж асуугаад байхгүй юу. 2025 онд төсөвлөсөн юу чинь жил нь хагасдаа орчхож байна. Энэ Хэрлэн-Тоонот усан цогцолбор дээр 7,6 тэрбум гээд тавьсан байгаа юм. Тэрүүгээр юу хийсэн юм гээд асуугаад байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: 2025 оны төсөв дээр хэрэгжээд явж байгаа юм гээд байхад чи тэгж ойлгож байгаа гэж хариулаад байж болохгүй шүү дээ. Тэр нь хэрэгжиж байгаа юм уу, үгүй юу гэж асуугаад байгаа юм байна шүү дээ. 2.

Ц.Эрдэнэбат: Би яг энэ хэрэгжилтийнх нь гүйцэтгэлийн байдлыг танд мэдээллийг нь аваад өгье. Энэ 2017 онд 17,9 биш ээ, 2025 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр 17,9, 2026 онд 13,5-ийн санхүүжилт төлөвлөгдөөд явж байгаа. Тэгээд үүний яг хэрэгжилт яг тэр төслийнхөө хэрэгжилт, санхүүжилтийнх нь задаргаа болон бүх мэдээллийг танд бичгээр хүргүүлбэ.

Ц.Даваасүрэн: Мэдээлэлгүй л байгаа юм байна л даа. Тендер шалгарсан ч юм уу, үгүй ч бас мэдэхгүй байгаа юм биш үү. Тэгээд та нар тэр гүйцэтгэгч энэ тэр шалгарсан юм бол тэрийг нь яагаад, ямар хэмжээний гүйцэтгэл гараад байгаа юм тэр мэдээллийг Ганбаатар гишүүнд өгөөрэй. Ер нь жоохон анхааралтай суу.

Гишүүдийн асуултад та нар тодорхой хариулахгүй бол үгүй ээ, тэр Батжаргал гишүүн та нараас тодорхой юм асуугаад байна шүү дээ. ТЭЗҮ-ийн үнэ өсчхөөд байна. Энэ хөрөнгө оруулалтын зураг төсвийн үнэ өсчхөөд байна гэхээр яамд нь ирүүлдэг юм. Бид нар хянадаггүй юм. Тэгээд л явуулчихдаг юм гээд сууж байж болохгүй шүү дээ. Тэр багцын төсөв нь танай дээр байгаа байхгүй юу.

Тийм учраас бас адаглаад хянадаг аргачлалтай болчихсон ийм байх хэрэгтэй. Дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж байгаа бол бусад яамддаа бүгдийг нь буцаагаад өгөх хэрэгтэй шүү дээ. Яг үнэндээ барилгын яам наадхыг чинь арай илүү хийх байх. Зураг төсвийг нь бол танайх биш. Тийм учраас энэ гишүүдийн яриад байгаа зүйл бол болохгүй болчихсон учраас л асуудал үүсэж байгаа талаар яриад байна шүү дээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авсан болж дуусах шиг боллоо. Ер нь цаашдаа бас Их Хурал өөрөө анхаармаар байгаа байхгүй юу. Яг дэд сайдаас доош албан тушаалтан бараг хариулахгүй гэж байгаад байгаа шүү дээ. Тэгэхэд чинь энд газрын дарга нар орж ирчхээд л миний дараагийн ахлах мэргэжилтэн хариул гээд гээд л. Ганбаатар гишүүний сая хурал удирдаад байна гэдэг шиг. Эд нар энд ямар ч хариулах эрхгүй байхгүй юу. Уг нь бол улс төрийн албан тушаалтан хариулах ёстой. Манайх ингээд хөл толгойгоо олохгүй, Засгийн газраа тархин дээрээ гаргаад авчихсан. Их Хурал нь сул болчихсон, уначихсан. Жил бүр л Их Хурал нь унаад л байдаг, унаад л байдаг. Төрийн дархлаа нь муудчихсан тийм юм бол намайг энэ Их Хуралд сууж байх хугацаанд бол эрс мэдрэгдэж эхэлж байна шүү дээ. Одоо бол сүүлдээ бүр хариулж байгаа 1 ч сайд байхгүй. Дандаа газрын дарга нар ороод ирчихсэн. Яах вэ одоо Төрийн нарийн бичгийн дарга нар харин орж ирсэн болоод, тэгээд энэ байдалд бас Засгийн газар анхаарах хэрэгтэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Тэгээд энэ санал хураалт дээр бас зарчим алдагдаж байгаа юм энэ тэр байх биз. Анхаарна биз дээ гишүүд ээ. Дэгийн хуулийн дагуу би заавал хураалгах ёстой. Гишүүд нь тайлбарлаарай. Төлөвлөгөө дээр чинь эрс өөрчлөлт орчих гээд байвал бас яамдууд хэлнэ шүү. Зарчим алдагдах гээд байгаа бол бас саналаа хэлээрэй. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө дээр шүү.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШБС-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам барих.” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “46,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “28,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.10 дахь заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин.

Түвшин өөрөө алга уу. Энэ саналын ямар нэг санал алга уу. Хөгжлийн яам байхгүй байгаа бол энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 2 гишүүн дэмжиж, 13,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

2 дахь санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 3.16 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний өртгийг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2, ШБС-1.2, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл арга хэмжээ “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт бүрдэх хатуу хучилттай авто замын үргэлжлэл” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн “137,500.0” гэж, Тухайн жилийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “30,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэсэн 3.16.2.11 дэх заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Түвшин. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 33,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ -1.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Орхон аймаг орон нутгийн бонд гаргаж, томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж-д “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүнд “0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийг “0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Үнэт цаас” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” 1.1.1.10 дахь дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Дэмжье гэсэн саналын томьёолол. Санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, 60 хувиар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-3.3.2.27” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ” гэж, Шалгуур үзүүлэлт “Авто замын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “20 хувь” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жил шаардлагын санхүүжилтийн хэмжилттэй “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал, “Үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” 1.1.1.12 дахь дэд заалт гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-6 дэмжиж, 40 хувиар дэмжигдсэнгүй.

Дамдинням гишүүн горимын санал. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Дарга аа, сая дэмжиж санал өгсөн боловч нөгөө хурууны хээ уншдаггүй. Эсрэг гарчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт хийх горимын санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар саяын хураагдсан саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, түрүүний санал хүчингүй боллоо. Дахин санал хураалт явуулъя. Батлут гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт дахин явуулъя. 15-8 гишүүн дэмжиж, 53,3 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үзүүлэлт “ЗГҮАХ-3.3.3.42” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулах шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “50,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэсэн 1.1.1.12 дахь дэд заалт гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, 60 хувиар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн бүсүүдийн тэмцэлтэй хөгжлийг хангасан байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логиستيкийн цогцолборыг хөтөлбөр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн хоршоодыг дэмжинэ.” гэж, Бодлогын үндэслэл “ЗГҮАХ-1.3.5.1, 1.3.1.4, 3.3.2.5, 3.3.2.22” гэж, Төсөл арга хэмжээ “Эрдэнэт хотод байгуулагдах бүсийн тээвэр логиستيкийн төвийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, батлуулах” гэж, Шалгуур үзүүлэлтийг “ТЭЗҮ” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “2,000.0” гэж, Тухайн жилд шаардах санхүүжилтийн хэмжээ “2,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар ТӨҮГ” гэж, 1.1.1.13 дахь дэд заалт нэмэх. Санал гаргасан их хурлын гишүүн Батлут. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-6, дэмжигдсэнгүй. 40 хувь.

Чи яг хэл дээ нөгөө Үндэсний аудитын газрын дүгнэлт, Санхүүгийн зохицуулах хорооных чинь юу билээ. Ганбатын 8 номерын микрофон өг дөө.

Ж.Ганбат: Дүгнэлт гаргаж байгаа эд нар дээр. Үндэсний аудитын газраас, тэгээд Санхүүгийн зохицуулах хорооноос, тэгээд Сангийн яамнаас бонд гаргахад зөвшөөрөл өгч байгаа юм. Дүгнэлт өгнө дандаа. Энэ бондыг гаргахад болно, болохгүй гэдэг дээр Үндэсний аудит, Санхүүгийн зохицуулах хороо, тэгээд зөвшөөрлийг нь Сангийн яам өгнө.

Ц.Даваасүрэн: Тийм нөгөө энэ бондоо төлж чадах уу гэдэг дүгнэлтийг нь Санхүүгийн зохицуулах хороо үнэлгээ хийдэг байхгүй юу.

Ер нь бонд гаргах гэдэг бол амаргүй тэгэхдээ амаргүй байх нь зөв. Яагаад гэвэл бүгд бонд гаргах юм бол энэ төсөв чинь ёстой утгагүй болж эхлэх байхгүй юу. Зүгээр яах вэ, Орхон аймаг, Өмнөговь аймаг бас харьцангуй боломжтой гэдэг агуулгаар л би яригдаж байгаа байх гэж бодоод байна. Зүгээр Өмнөговь яриагүй байгаа байх. Ярьж эхэлнэ л дээ одоо.

7.Төслийн 2 дугаар хавсралтын 2.3 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Олон улсад өрсөлдөхүйц, чанартай, тэгш, хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулж, хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгааг бууруулсан байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.1.19, ЗГҮАХ-2.2.1.7”, Төсөл арга хэмжээ “Олон жил гацсан ерөнхий боловсролын сургуулийн барилга барьж дуусах” гэж, Шалгуур үзүүлэлт “Ашиглалтад орох сургууль” гэж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн “40,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “40,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж, 2.3.1.9 дэх дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-4, 26,7 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Өөрийнх нь төхөөрөмж ажиллаагүй байна шүү. Батлут гишүүн бол өөрөө дэмжсэн байна.

8.Төслийн 2 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Өрсөлдөх чадвартай, тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Дээд боловсролын үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-9.5” гэж, Төсөл арга хэмжээ “Зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, Эрдэнэт хотод хотхон байгуулан шилжүүлнэ.” гэж, Шалгуур үзүүлэлт “Төслийн хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн “200,000.0” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нь “80,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв, үнэт цаас, орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар” гэж, 2.5.1.4 дэх дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батлут. Тайлбарлах юм уу. Батлут гишүүний микрофоныг өгье.

Тэгэхдээ энэ зөвхөн уул уурхайн чиглэлийн юм байгаа биз дээ. Энийгээ тайлбарлая. Батлут гишүүний микрофон.

Д.Батлут: Зарчмын зөрүүтэй саналууд оруулж өгч байгаа асуудлууд байгаа.

Тэгээд зарим нэг нь бас дэмжигдээд, зарим нэг нь дэмжигдэхгүй байна. Бас гишүүдэд материал өгөөгүйгээс болсон байх гэж бодож байна. Яах вэ, одоо орон нутгуудаас Өмнөговь, Орхон гээд хэдхэн аймаг л улсын төсөвт тэгшитгэдэг. Өөрөө өөрсдийгөө бие дааж санхүүжүүлдэг ийм л аймгууд байгаа. Орон нутгийн төсвийн эрх мэдлийг бас нэмэгдүүлэх хүрээнд бонд гаргах боломжуудыг ч гэсэн бид нар

хуулиараа заагаад өгчихсөн. Тэгээд үүнийгээ хэрэгжүүлэх санал, санаачилга гаргаж, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын газар ажиллаж, сая хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан дээр Засгийн газарт танилцуулж, бүсийн гишүүд энэ дээр санал гаргасан байгаа. Дэмжиж оролцсон. Энэ асуудлыг ер нь хэлэлцэж шийдвэрлээ гэдэг чиглэлээ Засгийн газарт протоколд дэмжлэг дэмжээд явж байгаа зүйл байна.

Тэгээд үүнийхээ хүрээнд бас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ бондын хөрөнгө оруулалтаар ямар ямар ажлуудыг хийх вэ гэдгийг санал асуулгын үндсэн дээр гаргаж, эрэмбэлээд, тэгээд энэ саналаа нааш нь ирүүлж байгаа. Тэгээд энэ саналын хүрээнд саналаа ирүүлж байгаа асуудал дээр бол хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд оруулах тусгал болгоод цааш нь хэрэгжүүлээд явах ёстой гэдэг утгаараа энэ баримт бичиг дээр тусгал болгох гээд зарчмын зөрүүтэй санал болгож оруулж ирсэн юм. Тэгээд энэ орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, дээрээс нь орон нутагт зайлшгүй хийх ёстой хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлэхийн тулд бонд босгож байгаа энэ саналуудыг дэмжиж өгөөсэй гэж гишүүдээсээ хүсмээр байгаа юм.

Ер нь бол бас төвлөрүүлдэг аймгууд төвлөрүүлээд л яваад байдаг. Орон нутагтаа яг төсвийн эрх мэдлийн хүрээнд бүрэн дүүрэн асуудлаа шийдэж чадахгүй ужгирсан зүйлүүд зөндөө байна шүү дээ. Дор хаяж л зам харгуйгаас авхуулаад дээрээс нь тэр дэд бүтэцтэй холбоотой асуудлууд гээд яг иргэдийн амьдрал ахуй тулчихсан асуудлууд олон байгаа. Эрдэнэт хотод гэхэд дэд бүтцийн асуудлыг шийдэхгүй бол цахилгаан, эрчим хүчний хувьд ч гэсэн орой үдэш буюу ид ачааллын үедээ 110 вольт л заадаг. Эрчим хүчээ ашиглах боломжгүй хэмжээнд хүрчихсэн тийм нөхцөл байдал үүсчихсэн байгаа байхгүй юу. Зам харгуй нь муудчихсан. Зарим нэг газраа бүр хуулаад хаячихсан байх жишээтэй. Энэ бүхнийгээ шийдчихье гэдэг байдлаар энэ саналуудыг оруулж ирж байгаа юм шүү. Тэгээд гишүүд маань энийг бас зөвөөр ойлгоорой.

Орхон аймаг бол байнга л улсад 130, 140 тэрбумаар нь төвлөрүүлж явсан. Энэ улсын үндсэн ачааллаас үүрэлцэж явж байгаа ийм л аймаг шүү дээ. Тэгэхээр энийг бид бүхэн бас 1 удаа боломж олгож, энэ хөрөнгө оруулалтыг нь орон нутгийн эрх мэдлийнх нь хүрээнд шийдэж өгөөд явах нь зүйтэй байх гэж бодож байна. Гишүүд маань энийг бас зөвөөр ойлгож дэмжиж өгөөрэй.

Мэдээж энэ бол орон нутгийн хөгжлийн зорилт, бүс нутгийн хөгжлийн зорилго зорилт мөн дээрээс нь бас Монгол Улсын хөгжлийн бодлого, Алсын хараа гээд бүх л зүйлтэй уялдуулсан хэлбэрээр төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх мэдлийн хүрээнд бас шийдчих боломжтой ч асуудлууд байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлмээр байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Энэ чинь зөвхөн санал гаргасан хүн л тайлбарладаг золиг юм байна шүү дээ. Тэгэхээр болохгүй болчихоод байхгүй юу. Үгүй ээ үгүй. Засгийн газрын хуралдааны шийдвэр ч гараагүй байгаа.

Уг нь бонд гаргах эрхээ авчихвал иргэдийн Хурал чинь шийдээд явчих юм байхгүй юу.

Зарим их, дээд сургуулиудын гэхээр чинь явах уу. Үгүй ээ үгүй. Уул уурхайн гэвэл бол пожалуйста л байгаа байхгүй юу. Уг уурхайн гэвэл. Зарим их, дээд

сургуулийн гэхээр очихгүй. Анагаах энэ тэр юу гэж очих юм бэ. Уул уурхай нь бол явах байх. Үгүй ээ үгүй. Тэгвэл энэ зарим их, дээд сургуулиудын гэгчхээд байгаа байхгүй юу. Яах вэ ШУТИС-ийн геологи, уул уурхай гэвэл танай тэнд багш олдоно. Тэрнээс биш байна шүү дээ энэ Улаанбаатарт амьдралаа тохижуулчихсан хүмүүс хэзээ ч бусад газар луу явж, багш хийдэггүй байхгүй юу. Багшлах боловсон хүчин олддоггүй байхгүй юу. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-6. Тэгвэл горимын санал. Ганбаатар гишүүний горимын санал. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Энэ Орхон аймагт уул уурхайн сургуулийн салбар нэхээд уг нь дэмжиж байгаа юм. Тэгээд сая саналаа өгсөн чинь миний санал техникийн

Ц.Даваасүрэн: Уул уурхайн сургууль гээд хураалгачихвал яадаг юм.

Г.Ганбаатар: Тийм ээ, бараг тэгж тодорхой орвол дээр л дээ. Санал маань дэмжигдсэнгүй. Тийм учраас хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Тэгэхгүй бол би зарим их, дээд сургууль гэвэл дэмжихгүй. Уул уурхайн гэх юм дэмжинэ. Боломжтой байхгүй юу. Тэнд бол ШУТИС-ийн угаасаа МСҮТ-ийн салбар нь ч байсан учраас энэ бол хөгжих боломжтой. Аль нь юм тэгээд. Тэгвэл зарим их сургуулийн гэдгийг ШУТИС-ийн уул уурхайн сургуулийг гэдгээр болж байна уу. Тэр чинь худлаа байхгүй юу. Хүчингүй болгоё гэсэн Ганбаатар гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, өмнөх санал хүчингүй боллоо.

Одоо 8 дахь Батлут гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-8, 53,3 хувиар энэ санал дэмжигдлээ.

9 дэх санал. Төслийн 2 дугаар хавсралтын 1.10.1.2 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Иргэдэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.” гэж, Бодлогын үзүүлэлт “АХ-2.2.4, 2.2.11, 2.2.27, ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл арга хэмжээ “Баруун бүсэд Зоонозын өвчин судлалын төвийн барилга шинээр барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн 4,18 тэрбум” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “2,09 тэрбум” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч Эрүүл мэндийн яам” гэсэн 1.10.1.2 дахь дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 15-5 гишүүн дэмжиж, 33,3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

10 дахь санал. Төслийн 2 дугаар хавсралтын 1.9 дэх заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, авто тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-8.1.2” гэж, Төсөл арга хэмжээ “Улаангом-Баруун туруун чиглэлийн 180км хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10 хувь” гэж, Нийт санхүүжилтийн дүн “360

тэрбум” гэж, Тухайн жилд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ “36 тэрбум” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч Зам, тээврийн яам” гэсэн 1.9.1.16 дахь дэд заалт нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-4 гишүүн дэмжиж, 26.7 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

11 дэх санал. Төслийн 2 дугаар хавсралтын хэд дэх заалт юм бол. 11 дэх саналыг Батлут гишүүн татаж авч байгаа юм уу. Батлут гишүүний микрофоныг өгье

Д.Батлут: Би энэ зарчмын зөрүүтэй саналын 11-14 дэх саналыг татаж авч байна. Яагаад гэвэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд бас зүйл заалт чиглэл бас байхгүй. Шинээр орж ирэх нөхцөл байдал үүсэж байгаа учраас би татаж авч байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн 11, 12, 13 14 дэх зарчмын зөрүүтэй саналуудаа татаж авч байна. Ингэснээр зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батболд гишүүн уншихаар боллоо.

Эхний асуудлыг хэлэлцэж дууслаа.

10.50 цаг.

2 дахь асуудал. **Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ юу. Л.Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Л.Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн

бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх ёстой. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл 1 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн 1 дэх зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал хураалт явуулах ёстой. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулна.

Найруулгын шинж чанартай нийтдээ 7 санал байгаа юм байна. Энэ найруулгын шинж чанартай санал байгаа. Энэ саналуудыг хураалгая.

“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Та бүхэнд тарчихсан байна уу. Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогын шалтгаалж Санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Найруулгын алдаа юм байна лээ. Санал хураалт яачхав. Дэмжье гэсэн саналыг нь томьёолол. Энэ чинь тэгээд үлдчихээр болчихлоо шүү дээ. Батжаргал гишүүн горимын санал. Батжаргал гишүүний микрофон.

Ж.Батжаргал: Саяын санал хураалтад дэмжиж санал өгсөн боловч санал хураалтад бүртгэгдсэнгүй. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, 60 хувиар өмнөх санал хүчингүй боллоо.

Тийм учраас 1 дэх зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор дахин санал хураалт явуулъя 15-7, 46 хувиар дэмжигдсэнгүй. Яах уу. 1 хураавал хураачихъя. Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Сая дэмжиж санал өгсөн. Энэ техникийн нөхцөлөөс болоод миний санал хураалтад орсонгүй. Тийм учраас дахиад явуулж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Гишүүдийг бас оруулъя. Ганбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-8, 53,3 хувиар өмнөх санал хүчингүй боллоо.

1 дэх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор дахин санал хураалт явуулъя. Анхаараарай гишүүд ээ. 15-7. Энэ санал дэмжигдсэнгүй. 46,7-оор.

2 дахь санал. Ингэе. Техникийн саатал гараад байгаа учраас санал хураалтыг гараар явуулъя гэдэг горимын санал гаргаж байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Үгүй ээ, гараар. 15-9 дэмжигдлээ. Тийм учраас санал хураалтыг гараар явуулъя.

Эхний саналыг тэгвэл дахиад хураачих уу. Хүчингүй болгож байгаад л явчихна шүү дээ. Эхний санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал гаргаж байна. Дэмжье гэсэн горимын санал хураалт явуулъя. 15-9 дэмжигдлээ.

Тэгээд 1 дэх саналыг дахин явуулъя.

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалж Санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 15-9 дэмжигдсэн байна.

2.Тогтоолын төслийн хавсралтын 2.7 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр” гэж, “2024 онд” гэснийг “2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр” гэж, 3.1 дэх хэсгийн “2 дугаар сард” гэснийг “2 дугаар сарын 18-ны өдөр” гэж, 3.3 дахь хэсгийн “6 дугаар сард” гэснийг “6 сарын 16-ны өдөр” гэж, 3.5 дахь хэсгийн “9 дүгээр сард” гэснийг “9 дүгээр сарын 2-ны өдөр” гэж, 3.6 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.7 дахь хэсгийн “5 дугаар сард” гэснийг “5 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 2.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 4-ний өдөр” гэж, 3.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 4-ний өдөр” гэж, 3.11 дэх хэсгийн “2031 онд” гэснийг “2031 оны 10 дугаар сарын 28-нд” гэж, 3.12 дахь хэсгийн “8 дугаар сард” гэснийг “8 дугаар сарын 29-ний өдөр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Аубакир гишүүн 15-9 дэмжигдсэн байна. Энэ санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын 8.4 дахь хэсгийн “эхлүүлэх” гэснийг “тогтмол явуулах” гэж, “тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.” гэснийг “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.” гэж тус тус

өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 15-9 дэмжигдсэн байна.

4.Тогтоолын төслийн хавсралтын Стратеги 4-ийн “Улсын төсөв ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед” гэснийг “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй үед” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 15-9 дэмжигдсэн байна.

Найруулгын санал.

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “түүхэн” гэсний өмнө “Засгийн газрын өмнө гаргаж байсан бондуудаас” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан” гэсний өмнө “баталгаа” гэж, 6.1 дэх хэсгийн “харьцааны төсөөллийг” гэсний өмнө “ДНБ-д харьцуулсан” гэж, 6.2 дахь хэсгийн “хэмжээг 2026 онд” гэснийг “ДНБ-нд эзлэх” гэж, Дүгнэлт хэсгийн “60,5 хувьтай” гэсний өмнө “2022 онд” гэж, “41,8 хувь” гэсний өмнө “2024 онд” гэж, “буурсан,” гэсний дараа “эдгээр онуудад” гэж тус тус нэмэх;

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх хэсгийн “оршино” гэснийг “чиглэнэ” гэж, “Сангийн яам нь стратегийн баримт бичгийг” гэснийг “Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг/цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/-ийг боловсруулж” гэж, 2.1 дэх хэсгийн “Цар тахлын” гэснийг “Ковид-19 цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын” гэж “2021 оноос 2024 оны хооронд нийт” гэснийг “2024 оны жилийн эцсийн байдлаар 2021 оны түвшнээс” гэж, “эзлэх хэмжээгээрээ” гэснийг “харьцуулсан харьцаа” гэж, 2.2 дахь хэсгийн “нэгжүүд” гэснийг “нэгж байгууллагууд гэж 3.2 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэснийг “нэмэгдүүлэх” гэж, 3.5 дахь хэсгийн “зээлийн эх үүсвэрийг” гэснийг “зээлийг” гэж, 3.9 дэх хэсгийн “буцаан төлж” гэснийг “бүрэн төлж” Хүснэгт 6-ын “өрийн зардал” гэснийг “өрийн багцын зардал” гэж, 5.4 дэх хэсгийн “буурах төсөөлөл” гэснийг “бууралт” гэж, Стратегийн 4-ын “бүх хэсгийн хүрээнд” гэснийг “нийт хэмжээнд” гэж, 5.8 дахь хэсгийн “үнэт цаасны гаргалтыг” гэснийг “үнэт цаасны арилжааг” гэж, 6.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн харьцаа” гэснийг “уг харьцаа” гэж, “өрийн харьцааг” гэснийг “уг харьцаа” гэж, 6.2 дахь хэсгийн “хүрээний мэдэгдэлд” гэснийг “төсөөлөлд” гэж “туссан дүнтэй” гэснийг “туссан хязгаарт” гэж тус тус өөрчлөх;

3.Тогтоолын төслийн 2.2 дахь хэсгийн “Голомт банкнаас” гэсний дараах “олон улсын зах зээлд” гэснийг, мөн хэсгийн “төрийн байгууллагуудын хувьд” гэснийг “болон гаргасан”, мөн “тус хугацаанд” гэснийг, 2.4 дэх хэсгийн “тогтмол” гэснийг 3.1 дэх хэсгийн “хуульчлагдаж” гэснийг, 5.8 дахь хэсгийн “түлхүү” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 15-9 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөлтэй Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төслийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг

батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аубакир чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

11.05 цаг.

3 дахь асуудалд оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг тараасан уу. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүний албан тушаал Төсвийн байнгын хорооны нэр дэвшвэл Улсын Их Хурлаас томилохоор заасны дагуу Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны албан тушаалд нэр бүхий иргэний нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн боловч нэр дэвшигчийн хүсэлтээсээ татгалзсан. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулах зорилгоор нэр дэвшигчийг бүртгэх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан.

Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

Нэр дэвшигч бүртгэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Байнгын хорооноос тогтоох нь.

1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийг 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч, нэр дэвшихийг бүртгэхээр тогтоосугай.

2.Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Төсвийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоол байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 15-9 байна. 15-9 тогтоолын төсөл дэмжигдсэн байна.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Баярлалаа гишүүд ээ.

11.08 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ